

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН

ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/1/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын  
захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан  
Утас: 261663 Цахим хаяг: [bayarsaikhand@audit.gov.mn](mailto:bayarsaikhand@audit.gov.mn)

Санхүүгийн аудитын газрын  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 260512 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)

Ахлах аудитор: А.Даваадорж  
Утас: 261628 Цахим хаяг: [davaadorja@audit.gov.mn](mailto:davaadorja@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал .....	13
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	23
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	31
4.1 Ерөнхий зүйл .....	31
4.2 Материаллаг байдал.....	31
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	31
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	31
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	32
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	32
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	37
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	38
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	39
5.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит .....	39
Аудитаар илэрсэн зөрчил .....	39
5.1.1. Албан шаардлага .....	39
5.1.2. Зөвлөмж .....	39
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	41

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АҮЭБС	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
ГСШТ	Геологийн судалгаа-шинжилгээний төв
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ҮГА	Үндэсний геологийн алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЭКАА	Цөмийн энергийн комиссын ажлын алба



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН  
САЙД Г.ДАМДИННЯМ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1123  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 131,430.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц байна. Тухайлбал:

- **Авлага, өглөгийн баталгаажуулалтын зөрчил:** Ашигт малтмал, газрын тосны газар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөртэй холбоотой 13,856.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, шатахууны нөөц, борлуулалт, тооцооны бүртгэлтэй холбоотой 9,821.9 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, 8,109.8 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулалт хангалтгүй;
- **Хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийн зөрчил:** Ашигт малтмал, газрын тосны газар 23,175.4 сая төгрөгийн шатахууны нөөцийг бодит үнэ цэнээр дахин үнэлээгүй, 8,884.0 сая төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй, Үндэсний геологийн алба 1,483.6 сая төгрөгийн хөрөнгийг буруу ангилсан, бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй;

- **Худалдан авах ажиллагаа болон гэрээний хэрэгжилт, хяналтын зөрчил:** Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны 41,204.2 сая төгрөгийн 21 ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, гэрээг эцэслэн дүгнээгүй, Эрчис-Ойл ХХК “Агаарын хөлгийн түлш худалдан авах гэрээ”-ний холбогдох заалтыг мөрдөөгүйгээс шатахууны үйлчилгээ, хадгалалтын 1,182.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 118.2 сая төгрөгийн ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулалгүй, төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулсан.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 8, 14, 54 дүгээр зүйлүүд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5, 18, 20 дугаар зүйлүүд, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 5, 10 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд геологи, уул уурхайн салбарын суурь мэдээллийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын нөөцийг шинээр тогтоох, бодитой үнэлэх зорилтын хүрээнд агаарын геофизик, геохими, зураглалын судалгааны ажлуудыг улсын төсвийн хөрөнгөөр шат дараатайгаар хэрэгжүүлсэн нь салбарын мэдээллийн санг баяжуулахад бодит ахиц авчирсан байна. Тодруулбал, агаарын геофизикийн судалгааг 154,200 км<sup>2</sup> талбайд, геологийн зураглалыг 1:50,000 масштабын түвшинд 43,055 км<sup>2</sup> талбайд, геохимийн судалгааг 41,000 км<sup>2</sup> талбайд тус тус хийж гүйцэтгэсэнээр ашигт малтмалын шинэ орд, илрэлийг тогтоох, цаашдын хөрөнгө оруулалтын суурь мэдээллийг бүрдүүлэх боломж нэмэгдсэн байна.

Үүний зэрэгцээ уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлд үндэсний стандарт, техникийн шаардлагуудыг шинэчлэн баталсан нь аудитын хувьд онцлох үр дүнтэй ажил болжээ. Тухайлбал: Аж үйлдвэрийн ялгарлын агаарын чанарт холбогдох MNS 7082:2025, MNS 7083:2025, MNS 7084:2025, MNS 7085:2025 стандартууд, Сайжруулсан шахмал түлшний MNS 5679:2025 стандартыг шинэчлэн баталснаар байгаль орчны хяналт, стандартын хэрэгжилтийг сайжруулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Мөн хүлэмжийн хийн ялгарлыг тооцох, тайлагнах тогтолцоог боловсронгуй болгох, нүүрстөрөгчийн зах зээл, ногоон санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах бодлогын дэмжлэг үзүүлжээ. Энэ нь уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, олон улсын шаардлагад нийцсэн “ногоон шилжилт”-ийг эхлүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудиторын мэргэжлийн шүүн тунгаалтаар тухайн тайлант хугацааны аудитад хамгийн чухал нөлөөтэй асуудлуудыг дараах байдлаар тодорхойлов.

Засгийн газрын 2023 оны “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 108 дугаар тогтоолын хавсралтаар баталсан тус компанийн дүрмийн 2.1.3-т компанийн энгийн хувьцаа эзэмшигчийг Монгол Улсын Засгийн газар, харин хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байхаар зохицуулжээ. Энэхүү эрх зүйн зохицуулалт болон өмнөх оны аудитаар өгсөн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг төрийн

эзэмшлийн хувь оролцоонд үндэслэн нэгтгэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд, 2024 онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцад нэгтгэгдэж байсан “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний хараат, охин компаниудын 2025 оны санхүүгийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад нэгтгэсэн байна.

Засгийн газрын 2025 оны 116 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 136 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Зам, тээврийн яамтай хамтран Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Чингис хаан” олон улсын нисэх буудлын “Шатахуун хангамжийн алба”-ыг, мөн Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолын дагуу газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тоог оновчтой болгох, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Зам-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ыг тус тус Эрчис ойл ХХК-д нэгтгэн зохион байгуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй боловч аудит, аудиторын хариуцлага, тайлангийн хэрэглээнд хамаарах асуудлуудыг дараах байдлаар тэмдэглэв.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт 11 зорилгын 35 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 145 арга хэмжээний биелэлт дунджаар 91.0 хувьтай гэж дүгнэгдсэн байна. Үүнээс 109 арга хэмжээ 85 хувиас дээш буюу бүрэн хангалттай, зорилтод түвшиндээ хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, бодит үр дүн гарсан гэж үнэлэгдсэн бол 10 арга хэмжээ 70–85 хувийн гүйцэтгэлтэй, харьцангуй дунд түвшний, сайжруулалт шаардсан дүнтэй гарсан байна. Харин 26 арга хэмжээ 70 хувиас доош буюу хангалтгүй хэрэгжсэн нь төлөвлөлт оновчгүй, төсөв, санхүүгийн эх үүсвэр дутмаг, хэрэгжилтийн явцад удирдлага, зохион байгуулалтын сул тал илэрснээс үүдэлтэй байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үзсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



СМ С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>215,680,176.3</b>	<b>236,643,378.7</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,345,827.5	24,476,687.7
33	АВЛАГА	16,986,950.5	47,350,681.9
34	УРЬДЧИЛГАА	96,883,205.3	105,207,880.0
35	БАРАА МАТЕРИАЛ	34,207,925.0	36,432,738.7
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390.4	23,175,390.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,080,877.6	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>171,022,566.0</b>	<b>213,074,034.8</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>171,022,566.0</b>	<b>213,074,034.8</b>
39200	Биет хөрөнгө	37,072,822.3	75,724,831.5
39300	Биет бус хөрөнгө	133,864,483.9	137,279,058.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	85,259.8	70,144.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>386,702,742.3</b>	<b>449,717,413.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,621,561.7</b>	<b>39,723,208.4</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,598,518.5</b>	<b>39,710,708.8</b>
41300	Өглөг	12,015,608.3	38,102,427.7
41400	Урьдчилж орсон орлого	28,582,910.2	1,608,281.1
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>23,043.2</b>	<b>12,499.6</b>
42200	Урт хугацаат зээл	23,043.2	12,499.6
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>346,081,180.6</b>	<b>409,994,205.1</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>346,081,180.6</b>	<b>409,994,205.1</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	11,613,105.6	10,513,229.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	21,112,954.3	22,212,830.7
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	12,872,663.6	53,056,361.5
51200	Хуримтлагдсан үр дүн	295,869,042.8	319,382,969.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,613,414.3	4,828,814.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>386,702,742.3</b>	<b>449,717,413.5</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>417,711,190.0</b>	<b>496,780,197.2</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	45,809,851.5	48,990,781.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,809,851.5	48,990,781.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	313,702,925.1	447,789,416.2
120	Нийтлэг татварын бус орлого	313,702,925.1	410,172,341.8
121	Хөрөнгийн орлого		28,265.0
122	Тусламжийн орлого		37,588,809.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,198,413.4	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>368,467,865.5</b>	<b>458,661,791.1</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,467,865.5	458,661,791.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,020,060.8	29,351,779.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,437,730.5	12,510,466.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,312,964.6	2,903,015.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	180,548.2	169,602.6
2104	Хангамж, бараа материалын зардал	534,312.9	368,945.1
2105	Нормативт зардал	1,113.2	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	546,635.8	149,086.4
2107	Томилолт, зочны зардал	539,283.8	343,436.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,987,047.6	10,067,090.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,480,424.2	2,840,136.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,447,804.6	429,310,011.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>49,243,324.5</b>	<b>38,118,406.1</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>1,642,537.1</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,059,649.6</b>	<b>322,107.0</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>43,183,674.9</b>	<b>39,438,836.2</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,561,148.0</b>	-	<b>288,561,148.0</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	14,850,042.6	-	14,850,042.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,411,190.6	-	303,411,190.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(730.7)	-	(730.7)
8	Зарласан ногдол ашиг	(512,954.2)	-	(512,954.2)
9	Тайлант үеийн үр дүн	43,183,674.9	-	43,183,674.9
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>346,081,180.6</b>	-	<b>346,081,180.6</b>
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	346,081,180.6	-	346,081,180.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4,145,097.4)	-	(4,145,097.4)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	40,183,697.9	-	40,183,697.9
17	Өмчид гарсан өөрчлөлт	(10,494,960.3)	-	(10,494,960.3)
18	Зарласан ногдол ашиг	(1,069,452.0)	-	(1,069,452.0)
19	Тайлант үеийн үр дүн	39,438,836.2	-	39,438,836.2
20	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>409,994,205.1</b>	-	<b>409,994,205.1</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	692,283,079.9	717,038,637.0
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	45,809,851.5	48,990,781.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,809,851.5	48,990,781.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,809,851.5	48,990,781.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	588,381,114.7	668,047,856.1
120	Нийтлэг татварын бус орлого	588,381,114.7	630,471,917.5
121	Хөрөнгийн орлого	-	8,110.0
122	Тусламжийн орлого	-	37,567,828.6
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	58,092,113.7	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	624,179,908.1	713,218,461.2
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	624,179,908.1	713,218,461.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,525,245.7	283,039,607.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,655,793.4	22,580,948.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,039,188.5	4,376,074.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	288,444.7	235,470.8
2104	Хангамж, бараа материалын зардал	214,535,905.9	153,187,275.5
2105	Нормативт зардал	4,889.0	2,750.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	579,599.3	186,181.3
2107	Томилолт, зочны зардал	564,864.9	333,897.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,230,615.1	100,535,710.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	625,945.0	1,601,299.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,654,662.4	430,178,853.5
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	68,103,171.8	3,820,175.8
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	887,069.8	3,538,000.6
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	41,402,964.8	16,151,793.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	41,402,964.8	16,151,793.6
2200	Дотоод эх үүсвэрээр	41,402,964.8	16,151,793.6
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	(40,515,895.0)	(12,613,793.0)
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	(2,825,484.7)	(5,075,522.7)
14	Бусад эх үүсвэр	45,225,785.4	95,829,970.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	48,051,270.0	100,905,493.0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>24,761,792.1</b>	<b>(13,869,139.9)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,584,035.4	38,345,827.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,345,827.5	24,476,687.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	46,858,542,100.00	39,406,525,078.72	7,452,017,021.28	84.1
12	Татварын бус орлого	46,858,542,100.00	39,406,525,078.72	7,452,017,021.28	84.1
120	Нийтлэг татварын бус орлого	5,426,954,400.00	4,019,089,721.00	1,407,864,679.00	74.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	5,426,954,400.00	3,965,321,721.00	1,461,632,679.00	73.1
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	53,768,000.00	(53,768,000.00)	
122	Тусламжийн орлого	41,431,587,700.00	35,387,435,357.72	6,044,152,342.28	85.4
122005	Төсвөөс санхүүжих	41,431,587,700.00	35,387,435,357.72	6,044,152,342.28	85.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,858,542,100.00	37,503,403,749.54	9,355,138,350.46	80.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,079,042,100.00	21,602,195,352.76	4,476,846,747.24	82.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,076,719,500.00	17,937,834,267.70	2,138,885,232.30	89.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,730,332,500.00	12,353,323,160.76	377,009,339.24	97.0
210101	Үндсэн цалин	7,140,984,700.00	6,977,904,137.72	163,080,562.28	97.7
210102	Нэмэгдэл	2,575,092,000.00	2,155,656,921.28	419,435,078.72	83.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,862,033,300.00	2,190,313,306.34	(328,280,006.34)	117.6
210104	Урамшуулал	1,152,222,500.00	1,029,448,795.42	122,773,704.58	89.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,647,962,300.00	1,553,581,633.24	94,380,666.76	94.3
210201	Тэтгэврийн даатгал	1,120,728,900.00	1,065,507,328.96	55,221,571.04	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	131,877,300.00	124,772,370.98	7,104,929.02	94.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	65,935,500.00	61,636,025.60	4,299,474.40	93.5
210204	Ажилгүйдлийн даатгал	65,884,000.00	59,401,295.32	6,482,704.68	90.2
210205	Эрүүл мэндийн даатгал	263,536,600.00	242,264,612.38	21,271,987.62	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	301,680,300.00	169,602,585.45	132,077,714.55	56.2
210301	Гэрэл, цахилгаан	145,856,600.00	66,667,816.05	79,188,783.95	45.7
210302	Түлш, халаалт	86,937,400.00	50,352,134.12	36,585,265.88	57.9
210303	Цэвэр, бохир ус	13,274,700.00	9,294,635.28	3,980,064.72	70.0
210304	Байрны түрээс	55,611,600.00	43,288,000.00	12,323,600.00	77.8
2104	Хангамж, бараа материалын зардал	339,643,800.00	272,851,838.83	66,791,961.17	80.3
210401	Бичиг хэрэг	63,034,900.00	43,629,382.00	19,405,518.00	69.2
210402	Тээвэр, шатахуун	32,491,200.00	30,759,600.00	1,731,600.00	94.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	172,597,700.00	137,582,786.83	35,014,913.17	79.7
210404	Ном, хэвлэл	250,000.00	250,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,007,200.00	840,000.00	1,167,200.00	41.8

**Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69,262,800.00	59,790,070.00	9,472,730.00	86.3
2105	Нормативт зардал	3,875,000.00	2,750,000.00	1,125,000.00	71.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,875,000.00	2,750,000.00	1,125,000.00	71.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,953,100.00	188,821,259.00	26,131,841.00	87.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,246,500.00	32,246,500.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,380,300.00	11,438,600.00	24,941,700.00	31.4
210604	Урсгал засвар	146,326,300.00	145,136,159.00	1,190,141.00	99.2
2107	Томилолт, зочны зардал	228,496,900.00	228,496,467.00	433.00	100.0
210702	Дотоод албан томилолт	228,496,900.00	228,496,467.00	433.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,506,351,100.00	3,065,460,982.72	1,440,890,117.28	68.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,139,724,000.00	2,728,632,534.14	1,411,091,465.86	65.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,030,700.00	5,000,000.00	1,030,700.00	82.9
210803	Даатгалын үйлчилгээ	36,511,400.00	34,383,770.00	2,127,630.00	94.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	13,756,100.00	12,748,716.25	1,007,383.75	92.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	934,700.00	396,000.00	538,700.00	42.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	252,947,800.00	231,957,843.33	20,989,956.67	91.7
210807	Газрын төлбөр	52,377,900.00	50,666,319.00	1,711,581.00	96.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,068,500.00	1,675,800.00	2,392,700.00	41.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,424,500.00	102,946,340.70	478,159.30	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,219,500.00	99,741,340.70	478,159.30	99.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,205,000.00	3,205,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,002,322,600.00	3,664,361,085.06	2,337,961,514.94	61.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,518,807,700.00	2,518,804,602.86	3,097.14	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,518,807,700.00	2,518,804,602.86	3,097.14	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,483,514,900.00	1,145,556,482.20	2,337,958,417.80	32.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	26,000,000.00	25,300,000.00	700,000.00	97.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,318,588,600.00	997,764,582.20	2,320,824,017.80	30.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	103,844,900.00	103,844,900.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,081,400.00	18,647,000.00	16,434,400.00	53.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,779,500,000.00	15,901,208,396.78	4,878,291,603.22	76.5
222001	Тоног төхөөрөмж	779,500,000.00	779,490,200.00	9,800.00	100.0
223001	Бусад хөрөнгө	20,000,000,000.00	15,121,718,196.78	4,878,281,803.22	75.6
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	1,903,121,329.18		

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	100.0
610001	Төсвийн байгууллага	4	4	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	332	328	4	98.8
620001	Удирдах ажилтан	43	42	1	97.7
620002	Гүйцэтгэх ажилтан	241	238	3	98.8
620003	Үйлчлэх ажилтан	48	48	-	100.0

## 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		1,672,368,840.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,672,368,840.87
122	Тусламжийн орлого		1,672,368,840.87
1221	Хандив тусламж /дотоод/		1,672,368,840.87
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,672,368,840.87
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		198,952,342.75
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,294,080,221.76
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		179,336,276.36
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,587,295,233.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,587,295,233.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,554,961,941.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		57,446,648.64
210101	Үндсэн цалин		57,446,648.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,959,820.11
210201	Тэтгэврийн даатгал		5,959,820.11
2104	Хангамж, бараа материалын зардал		4,000,000.00
210404	Ном, хэвлэл		4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		17,535,885.00
210702	Дотоод албан томилолт		17,535,885.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		102,074,092.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		102,074,092.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,367,945,495.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,345,071,380.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		22,874,115.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32,333,292.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		32,333,292.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		32,333,292.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		85,073,607.26

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2025 оны 07 дугаар тогтоолоор баталж, үйл ажиллагааны чиглэл, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь эрхэм зорилгоо “Монгол орны нутаг дэвсгэрийн геологийн судалгааг дээшлүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгох замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь үйл ажиллагааны 6 стратегийн зорилтын хүрээнд 54 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 3 хөтөлбөрийн 22 арга хэмжээний хэрэгжилтийг 64.9 хувиар, мөн Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 21 зорилтын хэрэгжилтийг 73.7 хувиар тус тус тайлагнасан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн эхний үе шатанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нийт 3 зорилтын 13 арга хэмжээ, хөгжлийн төслийн жагсаалтад орсон 11 төсөл, чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтад орсон 4 хуулийн төслийн хэрэгжилтийг хангах, нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээс гүйцэтгэл 59.6 хувьтай тайлагнасан байна.

Тайлант онд 11 зорилгын хүрээнд 145 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үр дүнгийн гүйцэтгэлийг төлөвлөн, гүйцэтгэлийг 91.0 хувьтай тайлагнасан байна.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг холбогдох хууль, бодлого чиглэл, дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

- Төсвийн тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна. Тухайлбал: Төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн, мөн төсвийн баримт бичгийн хугацааг богиносгон зохион байгуулалтын сахилга батыг сайжруулсан. Түүнчлэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран төсвийн бодлогын залгамж чанарыг хадгалах, эрх мэдлийн давхардлыг арилгах зохицуулалтыг тусгаснаар төсвийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн удирдлагын хяналтын орчныг бэхжүүлсэн байх;

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах, хэмнэлтийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Үүнд, зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүдэд нэмэлт хөлс, урамшуулал олгохыг хориглож, байгууллагын төсвөөр уралдаан, арга хэмжээ зохион байгуулах, семинар, хурал, томилолттой холбоотой зардлыг бууруулах, мөн албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах замаар бичиг хэргийн болон шуудангийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуульчилсан байх;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээ, нэгдсэн төсвийн тэнцвэржилт, төсвийн тодотголын зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн уян хатан болгох, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төсвийн тогтвортой байдлын шалгуур зөрчигдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Мөн төсвийн тогтвортой байдлын үзүүлэлт, тайлагналтай холбоотой зарим давхардсан заалтыг цэгцэлж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгосон байх.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь дараах үндсэн үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, төсвийн санхүүжилт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;
- Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дүгнэх, дүгнэлт зөвлөмж гаргах, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр, гэрээний хэрэгжилт болон иргэд, байгууллагын мэдээлэл, өргөдөл гомдлын мөрөөр дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний яам, төсөвт байгууллагууд, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж, зохих арга хэмжээг авах, зөвлөмж гаргах, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийж, дүгнэлт өгч, зөвлөмж гаргах чиг үүрэг хэрэгжүүлэх;

Сайдын 2025 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны газар, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ, Цөмийн энергийн комиссын ажлын алба зэрэг сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад санхүү, үйл ажиллагааны чиглэлээр дотоод аудит хийж, үр дүнг удирдлагад танилцуулсан;
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээнд аудит хийж, батлагдсан журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр шаардлага, зөвлөмж хүргүүлсэн;
- Өмнөх онуудад хийсэн аудитын мөрөөр зөвлөмжийн хэрэгжилтийг хянан, биелэлтийг үнэлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулсан байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцаж, тус газрын хариуцан хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнг аудитад ашигласан.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус яамны мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,014.6 сая төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,345.8	24,476.7	(13,869.1)
Авлага	16,987.0	47,350.7	30,363.7
Урьдчилгаа	96,883.2	105,207.9	8,324.7
Бараа материал	34,207.9	36,432.7	2,224.8
Нөөцийн бараа	23,175.4	23,175.4	-
Бусад эргэлтийн хөрөнгө	6,080.9	-	(6,080.9)
Үндсэн хөрөнгө	171,022.5	213,074.0	42,051.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>386,702.7</b>	<b>449,717.4</b>	<b>63,014.7</b>
Богино хугацаат өр төлбөр	40,598.5	39,710.7	(887.8)
Урт хугацаат өр төлбөр	23.0	12.5	(10.5)
Засгийн газрын хувь оролцоо	346,081.2	409,994.2	63,913.0
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>386,702.7</b>	<b>449,717.4</b>	<b>63,014.7</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо зэрэг данснууд байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 24,476.6 сая төгрөг болж, өмнөх оноос 13,869.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6.6</b>	<b>5.9</b>	<b>(0.7)</b>
Төгрөг	6.6	5.9	(0.7)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>38,339.3</b>	<b>24,470.8</b>	<b>(13,868.5)</b>
Төгрөг	37,656.1	24,405.2	(13,250.9)
Төрийн сангийн харилцах	18,164.8	18,556.3	391.5
Арилжааны банк дахь харилцах	19,491.3	5,848.8	(13,642.5)
Гадаад валют	683.2	65.6	(617.6)
Арилжааны банк дахь харилцах	683.2	65.6	(617.6)
<b>Дүн</b>	<b>38,345.8</b>	<b>24,476.7</b>	<b>(13,869.1)</b>

Эх сурвалж: АУЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны бүрэлдэхүүн, байршлын мэдээлэл: Кассанд байгаа бэлэн мөнгө дансанд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын 5.7 сая төгрөг, Эрчис ойл ХХК-ийн 0.2 сая төгрөг байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны нийт 18,556.3 сая төгрөгийн үлдэгдлийн дийлэнхийг Үндэсний геологийн албаны судалгааны ажлын барьцаа дансанд байрших 17,920.1 сая төгрөг бүрдүүлсэн бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналтын дансанд 636.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл нийт 5,848.8 сая төгрөг бөгөөд үүнээс Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ 3,933.6 сая төгрөг, Эрчис ойл ХХК 1,915.2 сая төгрөгийг тус тус байршуулсан байна.

Мөн арилжааны банк дахь гадаад валютын үлдэгдэл 65.6 сая төгрөг нь Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-д хамаарч байна.

Мөнгөн хөрөнгийн бууралтад дараах байгууллагуудын үйл ажиллагаа, мөнгөн гүйлгээ голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- **Эрчис ойл ХХК**-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,915.2 сая төгрөг болж, өмнөх оноос 5,477.8 сая төгрөгөөр буурсан нь зардлын өсөлттэй холбоотой байна. Тухайлбал, орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин хөлсний зардал 1,814.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 767.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээс гадна аж ахуйн нэгж, байгууллагуудад шилжүүлсэн төлбөр 2,885.8 сая төгрөг, Хаан банкнаас авсан зээлийн хүүгийн төлбөр 719.7 сая төгрөгөөр тус тус өссөн нь мөнгөн хөрөнгийн бууралтад нөлөөлсөн байна.
- **Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ**-ын хувьд төслийн санхүүжилт хугацаандаа орж ирээгүйгээс шалтгаалан худалдан авалт болон үйл ажиллагааны зардлыг оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлсэн бөгөөд үүний үр дүнд мөнгөн хөрөнгө 3,842.3 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд хийсэн хяналтын тооллогоор дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын кассанд 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хийсэн тооллогоор бэлэн мөнгөний үлдэгдэл 1.6 сая төгрөгөөр дутагдсан;
- Эрчис ойл ХХК-ийн кассанд 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар хийсэн тооллогоор бэлэн мөнгөний үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр дутагдсан байна.

**3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 47,350.7 сая төгрөг болж, өмнөх оноос 30,363.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	14.6	19.9	5.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	11.1	8.7	(2.4)
Татаас, санхүүжилтийн авлага	-	76.7	76.7
Дансны авлага /ТӨҮГ/	7,578.3	6,158.8	(1,419.5)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	944.8	2,773.0	1,828.2
Бусад авлага	8,438.1	38,313.5	29,875.4
<b>Дүн</b>	<b>16,987.0</b>	<b>47,350.7</b>	<b>30,363.7</b>

Эх сурвалж: АУЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Эрчис ойл ХХК-ийн авлага 12,665.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь холбогдох аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан агаарын түлш худалдах, худалдан авах, шатахуун хадгалалттай холбоотой гэрээний дагуу үүссэн авлага байна;
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын авлага 17,509.4 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хоёр төслийн санхүүжилт тайлант хугацаанд бүрэн орж ирээгүйтэй холбоотой байна.

Нийт авлагын үлдэгдлийн 42.6 хувь буюу 20,185.0 сая төгрөгийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ, 37.6 хувь буюу 17,801.9 сая төгрөгийг Эрчис ойл ХХК, 19.5 хувь буюу 9,252.8 сая төгрөгийг Ашигт малтмал, газрын тосны газрын авлага тус тус эзэлж байна. Харин Цөмийн энергийн комиссын ажлын алба, Үндэсний геологийн алба, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны авлагын үлдэгдэл харьцангуй бага буюу нийт авлагын 1 хувиас доош түвшинд байна.

Аудитын илрүүлэлт

Авлага дансны удирдлага, барагдуулалтын үйл ажиллагаанд сул тал ажиглагдаж, насжилттай болон баталгаажуулаагүй авлагын үлдэгдэл үүссэн, гэрээний хэрэгжилт хангалтгүйгээс шалтгаалан авлага өсөх, эргэн төлөгдөхгүй байх эрсдэл нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Ашигт малтмал, газрын тосны газар: Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн авлагын үлдэгдлээс олон жилийн насжилттай, 9 харилцагчтай холбоотой нийт 8,109.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах, шүүхийн болон шүүхийн өмнөх журмаар шаардах, тооцоо нийлж баталгаажуулах, холбогдох хариуцлагын арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын үе үеийн удирдлага, хариуцсан албан тушаалтнууд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам: Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст 12.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Үндэсний геологийн алба: Ажиллагчидтай холбоотой 12.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн бөгөөд төсвийн удирдлага, гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байгаагаас санхүүгийн сахилга бат алдагдаж, авлагын үлдэгдэл бодитой тусгагдахгүй байх эрсдэл бий болгосон;
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ: Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлагаас 401.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Уг авлагаас 225.1 сая төгрөгийн авлага 2014-2021 оны хооронд үүссэн, өмнөх байгууллагаас шилжиж ирсэн найдваргүй авлага байна.

- Эрчис ойл ХХК — Альфа аурора эвэйшн ХХК-аас авах 143.3 сая төгрөг, Изинис эйрвейз ХХК-аас авах 383.1 сая төгрөгийн өмнөх оны үлдэгдлийг барагдуулаагүй байна. Мөн “Агаарын хөлгийн түлш худалдах, худалдан авах гэрээ”-ний заалтыг мөрдөж ажиллаагүйгээс МИАТ ТӨХК-аас 2,215.4 сая төгрөг, Аэро монголиа ХХК-аас 1,323.0 сая төгрөг, Хүннү эйр ХХК-аас 224.5 сая төгрөг, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-аас 10.3 сая төгрөг, Мэргэван ХХК-аас 1,182.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 105,207.9 сая төгрөг болж, өмнөх оноос 8,324.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт +, Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	96,027.2	104,232.0	8,204.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	811.2	948.8	137.6
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	19.8	19.8
Томилолтын урьдчилгаа	44.8	7.3	(37.5)
<b>Дүн</b>	<b>96,883.2</b>	<b>105,207.9</b>	<b>8,324.7</b>

Эх сурвалж: АҮЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны 105,207.8 сая төгрөгийн үлдэгдлийн 89.6 хувийг Үндэсний геологийн алба, 9.3 хувийг Эрчис ойл ХХК бүрдүүлж байгаа бол үлдсэн 1.0 хувь нь Ашигт малтмал, газрын тосны газар, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд ногдож байна.

Үндэсний геологийн алба тайлант хугацаанд 16 геологийн судалгааны ажлын урьдчилгаа санхүүжилтэд 11,195.5 сая төгрөгийг шинээр олгосон нь урьдчилгаа дансны үлдэгдэл өсөхөд голлон нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт

Үндэсний геологийн алба нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байсны улмаас 21 төслийн гэрээний гүйцэтгэлийг эцэслэн дүгнээгүй, урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 41,204.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд зөв ангилан бүртгээгүй, дотоод хяналтын үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлээгүй, мөн уг чиг үүргийг хариуцсан мэргэжилтэн бүтэц, орон тоонд тусгагдаагүй байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 36,432.7 сая төгрөг болж, өмнөх оноос 2,224.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>179.8</b>	<b>318.3</b>	<b>138.5</b>
Тусгай зориулалттай материал	179.8	318.3	138.5
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>7,678.1</b>	<b>7,637.2</b>	<b>(40.9)</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>22,882.5</b>	<b>23,986.2</b>	<b>1,103.6</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>3,467.5</b>	<b>4,491.0</b>	<b>1,023.6</b>

Бичиг хэргийн материал	56.3	44.5	(11.9)
Аж ахуйн материал	1,120.7	1,189.2	68.5
Сэлбэг хэрэгсэл	29.1	35.7	6.7
Түлш, шатах тослох материал	12.1	0.1	(12.0)
Бусад хангамжийн материал	2,249.3	3,221.5	972.3
<b>Дүн</b>	<b>34,207.9</b>	<b>36,432.7</b>	<b>2,224.8</b>

Эх сурвалж: АҮЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 66.1 хувийг Эрчис ойл ХХК, 16.3 хувийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрөнгө оруулалтын данс, 10.7 хувийг Аж үйлдвэрийн, эрдэс баялгийн яамны аппарат, 4.5 хувийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ, үлдсэн 2.3 хувийг Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Цөмийн энергийн комиссын ажлын алба тус тус эзэлж байна.

Эрчис ойл ХХК-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2,338.0 сая төгрөгөөр өссөн нь бараа материалын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Тус компани тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 499,290.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 496,952.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан бөгөөд үүнээс онгоцны түлш 496,295.1 сая төгрөг буюу нийт бараа материалын 99.0 хувийг бүрдүүлж байна.

Мөн тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 136 дугаар тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газраас 306.0 сая төгрөгийн бараа материалыг орлогод тусгасан байна.

#### Аудитын илрүүлэлт

Бараа материалын дансны ангилал, хүлээн зөвшөөрөлтийн шалгуур зөрчигдсөн, үндсэн хөрөнгийн шинж чанартай активыг буруу ангилан бүртгэсэн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Ашигт малтмал, газрын тосны газар нь 388 ширхэг, 89.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй активыг бараа материалын дансанд бүртгэсэн;
- Үндэсний геологийн алба нь ашиглалтын хугацаа нэг жилээс дээш, үйл ажиллагаанд давтан ашиглагдах 11.1 сая төгрөгийн өртөг бүхий дрон, цахилгаан үүсгүүр, зам заагч төхөөрөмж, принтер, архивын тавиур, сандал зэрэг активыг мөн бараа материалын дансанд буруу ангилан бүртгэсэн байна.

#### **3.4.5 Нөөцийн бараа**

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 23,175.4 сая төгрөг бөгөөд өмнөх оноос өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 6. Нөөцийн бараа

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Шатахууны нөөц	23,175.4	23,175.4	0.0
<b>Дүн</b>	<b>23,175.4</b>	<b>23,175.4</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: АҮЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны дансанд Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцаж буй 23,175.4 сая төгрөгийн өртөг бүхий улсын нөөцийн шатахууны үлдэгдэл бүртгэгдсэн байна. Энэхүү шатахуун нь улсын стратегийн нөөцөд хамаарах бөгөөд онцгой болон шаардлагатай нөхцөлд ашиглах зориулалттай, тусгай горимын дагуу бүртгэгдэж, хадгалагддаг онцлогтой байна.

### Аудитын илрүүлэлт

Ашигт малтмал, газрын тосны газрын нөөц дансанд бүртгэлтэй 23,175.4 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй улсын нөөцийн шатахууныг өнөөгийн бодит өртгөөр (үнэ цэнээр) дахин үнэлж бүртгэлд тусгаагүй байна.

Засгийн газрын 2025 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын А/86, А/128 дугаар тушаалаар гэрээгээр шатахуун хадгалагч 7 компанид хадгалагдаж байсан зуны дизель түлшний улсын нөөцөөс 5,191.6 тонн түлшийг зах зээлийн үнээр борлуулж, олсон орлогоор ТС-1 онгоцны түлшний улсын нөөц бүрдүүлэх чиг үүргийг “Эрчис-Ойл” ХХК-нд хариуцуулсан байна.

Уг чиглэлийн дагуу “Эрчис-Ойл” ХХК тайлант онд 3,506.8 тонн дизель түлшийг 6 компаниас хүлээн авч 9,821.9 сая төгрөгөөр борлуулсан боловч энэ гүйлгээтэй холбоотой бараа материалын тооцоо, авлага, өглөгийг Ашигт малтмал, газрын тосны газар санхүүгийн тайландаа бүртгээгүй байна.

### 3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй болж, өмнөх оноос 6,080.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгө

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	6,080.9	0.0	(6,080.9)
<b>Дүн</b>	<b>6,080.9</b>	<b>0.0</b>	<b>(6,080.9)</b>

Эх сурвалж: АҮЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Зам-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ыг Эрчис ойл ХХК-д нэгтгэн зохион байгуулснаар тус байгууллагын бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 6,080.9 сая төгрөгийн хадгаламжийг Эрчис ойл ХХК-д шилжүүлсэн байна.

### 3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 213,074.0 сая төгрөг болж, өмнөх оноос 42,051.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>37,072.8</b>	<b>75,724.8</b>	<b>38,652.0</b>
Барилга, байгууламж, орон сууц	18,818.0	46,626.0	27,808.0
Авто-тээврийн хэрэгсэл	1,558.8	5,692.0	4,133.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,888.8	16,503.0	6,614.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	634.7	760.5	125.8
Бусад үндсэн хөрөнгө	1,136.9	1,107.7	(29.2)
Дуусаагүй барилга, байгууламж	5,033.9	5,033.9	-
Ном	1.7	1.7	-
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>133,864.5</b>	<b>137,279.1</b>	<b>3,414.6</b>
Программ хангамж	279.2	1,533.2	1,254.0
Бусад биет бус хөрөнгө	133,585.3	135,745.9	2,160.6
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	<b>85.3</b>	<b>70.1</b>	<b>(15.1)</b>
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	85.3	70.1	(15.1)
<b>Дүн</b>	<b>171,022.6</b>	<b>213,074.0</b>	<b>42,051.5</b>

Эх сурвалж: АҮЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн нийт 213,074.0 сая төгрөгийн дүнгээс дийлэнх буюу 64.3 хувийг Үндэсний геологийн алба, 23.7 хувийг Эрчис ойл ХХК, 5.0 хувийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ тус тус бүрдүүлж, үлдэх 7.0 хувь нь Ашигт малтмал, газрын тосны газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Цөмийн энергийн комиссын ажлын албанд хамаарч байна. Тайлант жилд 42,051.4 сая төгрөгийн хөрөнгийн өсөлтөд Эрчис ойл ХХК-ийн үндсэн хөрөнгийн нэмэгдэл зонхилон нөлөөлсөн байна.

Тодруулбал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 136 дугаар тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг Эрчис ойл ХХК-д шилжүүлэн бүртгэснээр нийт 54,807.9 сая төгрөгийн хөрөнгө орлогод авсан байна. Үүнд 186.9 сая төгрөгийн 1 газар, 36,043.3 сая төгрөгийн 21 барилга байгууламж, 13,156.4 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, 25.4 сая төгрөгийн хэвлэх, хувилах төхөөрөмж, 5,053.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 140.6 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 194.4 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, 7.4 сая төгрөгийн эрх тус тус багтаж байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч одоог хүртэл ашиглагдаж байгаа нийт 2,824 нэгж, 10,424.1 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй, мөн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй; Үүнд: Ашигт малтмал, газрын тосны газар 2,361 нэгж, 8,884.0 сая төгрөг; Үндэсний геологийн алба 275 ширхэг, 1,472.5 сая төгрөг; Эрчис ойл ХХК 188 нэр төрлийн 67.6 сая төгрөгийн хөрөнгө тус тус хамаарч байна.
- Цөмийн энергийн комиссын ажлын алба: Улсын төсвийн хөрөнгөөр байгууллагын сан техникийн шугам хоолойг бүрэн хэмжээнд сольж 74.7 сая төгрөгийн их засвар хийсэн боловч капиталжуулан үндсэн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэн бүртгээгүй;
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ: Үндсэн хөрөнгийн 2025 оны элэгдлийг давтан тооцоолоход 207.9 сая төгрөгийн элэгдлийг илүү, 30.7 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцон бүртгэсэн;
- Ашигт малтмал, газрын тосны газар: Ухаалаг шийдэл ХХК-тай байгуулсан "Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний дагуу газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулах mpetro.smartsolution.mn системийг нийт 255.0 сая төгрөгийн өртгөөр хүлээн авч, 2020 оноос ашиглаж эхэлсэн боловч уг системийг биет бус хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

**3.4.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 39,723.2 сая төгрөг болж, өмнөх оноос 898.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,598.5</b>	<b>39,710.7</b>	<b>(887.8)</b>
Өглөг	12,015.6	38,102.4	26,086.8
Урьдчилж орсон орлого	28,582.9	1,608.3	(26,974.6)
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>23.0</b>	<b>12.5</b>	<b>(10.5)</b>
Урт хугацаат зээл	23.0	12.5	(10.5)
<b>Дүн</b>	<b>40,621.5</b>	<b>39,723.2</b>	<b>(898.3)</b>

Эх сурвалж: АҮЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өр төлбөрийн нийт 39,723.2 сая төгрөгийн дүнгээс дийлэнх буюу 51.5 хувийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ, 36.9 хувийг Эрчис ойл ХХК, 6.3 хувийг Үндэсний геологийн алба тус тус бүрдүүлж, үлдэх 5.3 хувь нь Ашигт малтмал, газрын тосны газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Цөмийн энергийн комиссын ажлын албанд хамаарч байна.

Тайлант жилд бүртгэгдсэн 898.3 сая төгрөгийн бууралтад Эрчис ойл ХХК-ийн өр төлбөрийн бууралт голлон нөлөөлсөн байна.

Тодруулбал, тус компанийн гэрээт худалдан авагчид гэрээний үүргээ биелүүлж, худалдан авсан барааны төлбөрийг төлснөөр богино хугацаат өр төлбөр 14,648.1 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Ашигт малтмал, газрын тосны газар: Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн орлоготой холбоотойгоор 1998–2016 онд тусгай зөвшөөрөл эзэмшсэн 12 эзэмшигчид хамаарах 2,398,398.39 ам.доллар (ханш 1 ам.доллар = 3,556.66 төгрөг), мөн 2017–2025 онд тусгай зөвшөөрөл эзэмшсэн 20 эзэмшигчид хамаарах 5,326.2 сая төгрөгийн үлдэгдэл, нийт 13,856.5 сая төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна. Мөн сонгон шалгаруулах тендерт шалгараагүй 68 харилцагчид өгөх 1,133.1 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 55 харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам: Тайлант оны эцэст нийт 215.4 сая төгрөгийн өр төлбөр өглөгийг үүсгэсэн;
- Үндэсний геологийн алба: Бараа, ажил, үйлчилгээний зардлаас үүдэлтэй 49.7 сая төгрөгийн өглөгийг үүсгэсэн;
- Эрчис ойл ХХК: Ашигт малтмал, газрын тосны газраас 36.8 сая төгрөг, 11 компаниас 9,785.2 сая төгрөгийн дизель түлш авч, нийт 9,822.0 сая төгрөгийн дансны өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

**3.4.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 409,994.2 сая төгрөг болж, өмнөх оноос 63,913.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Өмчийн өөрчлөлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	11,613.1	10,513.2	(1,099.9)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	21,112.9	22,212.8	1,099.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	12,872.7	53,056.4	40,183.7
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>295,869.0</b>	<b>319,382.9</b>	<b>23,513.9</b>
Өмнөх үеийн үр дүн	252,685.4	279,944.1	27,258.7
Тайлант үеийн үр дүн	43,183.6	39,438.8	(3,744.8)
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>4,613.4</b>	<b>4,828.8</b>	<b>215.4</b>
<b>Дүн</b>	<b>346,081.2</b>	<b>409,994.2</b>	<b>63,913.0</b>

Эх сурвалж: АУЭБС-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өмчид нийт 63,913.0 сая төгрөгийн өөрчлөлт гарсан бөгөөд үүнд Эрчис ойл ХХК-ийн эздийн өмчийн бусад хэсгийн 40,183.7 сая төгрөгийн өсөлт, мөн харьяа байгууллагуудын хуримтлагдсан үр дүн 23,513.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бүтцийг оновчтой болгох, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Зам-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ыг Эрчис ойл ХХК-д нэгтгэн зохион байгуулснаар эздийн өмчийн бусад хэсэг 40,183.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант үеийн нийт үр дүн 39,438.8 сая төгрөг бөгөөд харьяа 3 төрийн өмчит байгууллага нийт 24,528.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Тодруулбал:

- Эрчис ойл ХХК 20,538.5 сая төгрөг
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ 2,818.1 сая төгрөг;
- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ 1,171.7 сая төгрөг

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг ирүүлсэн байна.

#### 3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 74,432.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,426.9 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тооцож, урсгал зардлыг 27,059.5 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 52,800.0 сая төгрөг, нийт зарлагыг 79,859.5 сая төгрөгөөр төлөвлөн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар тус төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын улсын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 309,209.6 сая төгрөгөөр, харьяа төсөвт байгууллагын өөрийн орлогыг 5,427.0 сая төгрөгөөр баталсан байна.

Мөн хуулиар урсгал зардлыг 26,079.0 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 20,779.5 сая төгрөгөөр баталж, нийт зарлагын хэмжээг 46,858.5 сая төгрөгөөр тогтоосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

##### Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Гүйцэтгэлээр улсын төсөвт 422,842.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөө 136.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл

					/сая төгрөг/
№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл (хувь)
1	Газрын тосны орлого	249,694.5	231,865.0	(17,829.5)	92.9
2	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	29,984.0	45,776.2	15,792.2	152.7
3	Өөрийн орлого (Сонгон шалгаруулалт)	25,000.0	137,895.9	112,895.9	551.6

4	Үйлчилгээний орлого /газрын тос/	2,279.1	3,780.6	1,501.5	165.9
5	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,132.0	3,214.6	1,082.6	150.8
6	Үйлчилгээний орлого /архив лавлагаа/	120.0	310.6	190.6	258.8
<b>Нийт дүн</b>		<b>309,209.6</b>	<b>422,842.9</b>	<b>113,633.3</b>	<b>136.7</b>

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтаар 2025 онд улсын төсөвт 25,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан бол жилийн эцсийн байдлаар 137,895.9 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 551.6 хувиар биелүүлсэн байна.

Орлогын энэхүү огцом өсөлтөд сонгон шалгаруулалтыг тогтмол, тасралтгүй зохион байгуулсан, босго үнийг тооцох га талбайн үнэлгээ нэмэгдсэн, мөн оролцогч аж ахуйн нэгжүүдээс харьцангуй өндөр үнийн санал ирүүлсэн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Газрын тосны орлого төлөвлөсөн хэмжээнээс 7.1 хувиар буюу 17,829.5 сая төгрөгөөр тасарсан байна. Орлогын энэхүү бууралт нь 2025 онд улсын нийт газрын тосны олборлолтын 94 хувийг бүрдүүлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хууль, эрх зүй, дэд бүтэц, нийгмийн орчны шинжтэй хүчин зүйлс зэрэгцэн нөлөөлж, батлагдсан олборлолтын төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Тухайлбал, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээ болон 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн зохицуулалтын уялдаа, хэрэгжилтийн хүрээнд үүссэн эрх зүйн тодорхой бус байдал нь хөрөнгө оруулагч талын шийдвэр гаргалтад нөлөөлж, 2025 онд батлагдсан ажлын төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагааг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх боломжийг хязгаарлажээ.

Үүний үр дүнд хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, зарим төлөвлөсөн ажлууд хойшлогдсон байна.

Үүнээс гадна цахилгаан эрчим хүчний хангамжийн доголдол, салбарын үйл ажиллагаатай холбоотой ташаа мэдээлэл олон нийтэд тархсан зэрэг нийгмийн орчны эрсдэлүүд нь үйлдвэрлэлийн хэвийн горимд сөргөөр нөлөөлсөн.

Иймд орлогын тасралт нь эрх зүйн орчны тогтворгүй байдал, хөрөнгө оруулалтын бууралт, дэд бүтцийн хязгаарлалт болон нийгмийн орчны эрсдэл зэрэг нийлмэл хүчин зүйлс нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Үндэсний геологийн алба: Сүүлийн 3 жилийн улсын төсвийн орлогын төлөвлөгөө 110.0-130.0 сая төгрөгөөр батлагдсан боловч гүйцэтгэл 310.6-734.8 сая төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 2.6-5.6 дахин давсан байна. Энэ нь орлогыг бодит бус, дутуу төлөвлөж, төсвийн санал, тооцоог үндэслэлгүйгээр боловсруулж хүргүүлсэнтэй холбоотой.
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ: Харилцагч нараас хүлээн авсан 527.9 сая төгрөгийн шинжилгээний орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгээгүй байна.

#### **Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт**

Улсын төсвөөс 35,387.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 4,019.0 сая төгрөг бүрдүүлэн нийт 37,503.4 сая төгрөгийг зарцуулж, үлдсэн 1,903.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 37,503.4 сая төгрөг буюу 80.0 хувьтай гарсан нь геологи, хайгуул, судалгааны зардалд төлөвлөсөн санхүүжилт бүрэн олгогдоогүй, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэг, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны зардлыг дутуу зарцуулсан, мөн зарим хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I</b>	<b>70905 Олборлолт, уул уурхай</b>	<b>42,001.0</b>	<b>32,818.8</b>	<b>9,182.2</b>	<b>78.1</b>
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	14,470.6	13,894.3	576.4	96.0
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	12.4	2.4	10.0	19.6
3	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	136.5	40.5	96.0	29.7
4	80219 Харуул, хамгаалалтын зардал	136.8	129.6	7.2	94.8
5	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	896.9	745.1	151.8	83.1
6	80227 Лабораторийн итгэмжлэл	2.6	0.0	2.6	0.0
7	80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад	256.2	256.1	0.1	99.9
8	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	148.6	132.2	16.4	88.9
9	80809 Эмчилгээний төлбөр	17.3	15.0	2.3	86.5
10	80914 Геологи хайгуул, судалгаа	20,000.0	15,121.7	4,878.3	75.6
11	81706 Химийн хорт бодисыг хоргүйжүүлэх арга хэмжээ	4.3	4.3	0.0	100.0
12	81820 Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэг	3,060.1	741.7	2,318.3	24.2
13	82401 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	491.7	415.4	76.3	84.5
14	82410 Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө	2,366.9	1,320.5	1,046.4	55.8
<b>II</b>	<b>70906 Эрчим хүч, уул уурхайн бодлого</b>	<b>779.5</b>	<b>779.5</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
1	80918 Бусад	779.5	779.5	0.0	100.0
<b>III</b>	<b>71805 Шинжлэх ухаан, технологи</b>	<b>4,078.0</b>	<b>3,905.1</b>	<b>173.0</b>	<b>95.8</b>
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,466.4	1,314.9	151.4	89.7
2	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	91.6	70.8	20.8	77.3
3	80509 ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	2,518.8	2,518.8	0.0	100.0
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1.3	0.6	0.7	46.2
<b>Нийт дүн</b>		<b>46,858.5</b>	<b>37,503.4</b>	<b>9,335.1</b>	<b>80.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

**Ажилтны цалин хөлс, урамшуулал, нэмэгдэл олголттой холбоотойгоор дараах зөрчил илэрлээ.**

- Ашигт малтмал, газрын тосны газар: Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах үйлчлэгч, цэвэрлэгч, архивч, бичиг хэргийн ажилтан, орон нутгийн төлөөлөгч, жолооч зэрэг байнгын шинжтэй, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах ажлын үүргийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, Иргэний хуулийн дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан;

- Мөн Төрийн албаны тухай хуулийн дагуу албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тохиолдолд 14 хоногийн дотор шийдвэр гаргаж, холбогдох нэмэгдэл хөлсийг тооцох ёстой боловч энэхүү хугацааг мөрдөөгүй, шийдвэрүүдийг удаашруулан гаргасан байна.
- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ: 2025 оны үр дүнгийн шагналд тайлант жил дуусаагүй байхад захирлын тушаалаар 5 сарын үндсэн цалинтай тэнцэх 279.9 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- Үндэсний геологийн алба: Тооцооны нягтлан бодогч байгууллагын даргын зохих тушаал, шийдвэргүйгээр 100 хувийн үр дүнгийн урамшуулал тооцон 1.3 сая төгрөгийг олгосон;
- Цөмийн энергийн комиссын ажлын алба: 5 ажилтанд амралтын мөнгийг ажилласан хоногийн цалинтай давхардуулан 8.4 сая төгрөг олгосон;

**Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ:**

- Шинээр ажилд орсон 3 ажилтанд батлагдсан цалингийн сүлжээнээс илүү дүнгээр үндсэн цалинг тогтоож 10.8 сая төгрөгийг илүү олгосон; Мөн дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос илүү цаг, шөнийн цагийн нэмэгдлийг 2.6 сая төгрөгөөр илүү тооцож олгосон;
- Мөн 2025 онд ажилд орсон 9 ажилтанд 6.1 сая төгрөгийн 2024 оны үр дүнгийн урамшуулал олгосон байна.

**Томилолтын зардлын төлөвлөлт, баримт бүрдэл, хязгаартай холбоотойгоор дараах зөрчлүүд илэрлээ.**

**Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам:**

- Тайлант онд нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүй;
- Дотоод томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1.1 сая төгрөгийг илүү олгосон, гадаад томилолтын зардал олгохдоо мөн зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 16.5 сая төгрөгийг илүү олгосон;

**Үндэсний геологийн алба:**

- Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалын дагуу Хэнтий, Дорнод аймгийн суманд хийсэн хяналт шалгалт, сургалтын томилолтын зардалд 4.4 сая төгрөгийг зарцуулсан нь Үндэсний геологийн албаны чиг үүрэгт хамаарахгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

**Төсвийн хөрөнгийг зориулалтаас өөрөөр зарцуулсан дараах зөрчлүүд илэрлээ.**

- Ашигт малтмал, газрын тосны газар: "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам"-д нийцээгүй зорилго, зориулалтаар нийт 417.5 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. Үүнд: сайдын хэрэгцээнд 370.0 сая төгрөгийн автомашин худалдан авсан, нэвтрэх хаалга, удирдлагын системд 28.0 сая төгрөг, зам, талбайн засварт 19.5 сая төгрөг зарцуулсан;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам: Өөрийн бүртгэлд байхгүй, Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг сайдын албан хэрэгцээнд ашиглаж, яамны батлагдсан төсөвт тусгагдаагүй 2.8 сая төгрөгийг зарцуулсан;
- Эрчис ойл ХХК: Зочид төлөөлөгчдөд гарын бэлэгт 1.6 сая төгрөг, шинэ жилийн хүүхдийн бэлэгт 17.3 сая төгрөг зарцуулж байгууллагын хөрөнгийг зохисгүй, үрэлгэн зарцуулсан;

- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ: Гадаадын зочид, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зориулалтаар 12.4 сая төгрөгийн өртөг бүхий 70 ширхэг чулуун бүтээгдэхүүнийг захирлын тушаал, шийдвэргүй зарцуулсан;
- Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин ТӨҮГ: "Спорт 7 төрөлт" тэмцээний зардалд 3.6 сая төгрөг зарцуулсан.

### 3.5.3 Тухайн жилийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/106, А/107, А/108 дугаар тушаалуудаар сайдын багцын хэмжээнд 2025 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг баталж, нийт 54 арга хэмжээ, 22,029.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авалтыг төлөвлөсөн байна. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны А/24 дүгээр тушаалаар Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө батлагдсантай уялдуулан сайдын 2025 оны А/43 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, 2025 оны А/79 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан тодотгосон байна. Мөн Эрчис ойл ХХК-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан, цахимаар баталгаажуулж, тус компанийн хувьд 9 арга хэмжээ, 5,860.4 сая төгрөгийн худалдан авалт төлөвлөгдсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 багц, нийт 984.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг холбогдох журмын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж, тус газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу 3 багцад нийт 779.5 сая төгрөгийн гэрээг шалгарсан оролцогчидтой байгуулсан байна. Үүнд багц 1-д "Саммит компьютер технологи" ХХК, багц 2-т "Арвис системс" ХХК, багц 3-т "Хөтөл нутаг" ХХК тус тус шалгарсан бөгөөд холбогдох мэдээллийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд бүртгэсэн байна.

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулах зорилгоор нийт 8 үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулж, тендер шалгаруулалтыг үе шаттайгаар зохион байгуулсан байна.

Энэ хүрээнд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан боловсруулах 109.0 сая төгрөг, байрны түрээс 96.0 сая төгрөг, эрдэм шинжилгээ, судалгааны ажил 134.9 сая төгрөг, багаж, техник, хэрэгсэл худалдан авах 99.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний 3 багц нийт 99.7 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг тус тус зохион байгуулж, шалгарсан оролцогчидтой гэрээ байгуулсан байна. Түүнчлэн ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс компьютер худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 13.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу 2025 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тайлангийн хавсралтаар ерөнхий гэрээний журмаар худалдан авсан бараа, үйлчилгээний мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж тайлагнасан бөгөөд худалдан авах ажиллагаатай холбоотой тайлан, мэдээллийг сар бүр "Шилэн дансны цахим систем болон байгууллагын веб хуудсанд байршуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Ашигт малтмал, газрын тосны газар: Нэг ижил объектод хамаарах, нэг ижил эцсийн үр дүнтэй, нэг гүйцэтгэгчээр, нэг хугацаанд гүйцэтгэх нийт 36.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж, 2 гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн;

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам: Үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хуваах замаар нийт 6 байгууллагатай шууд гэрээ байгуулж 118.2 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн. Мөн төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 23.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан байна.

### **3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тайлант онд хэрэгжүүлэх уул уурхайн олборлолтын 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнүүд нь геологи, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, ашигт малтмалын нөөцийн судалгаа, олборлолт, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, улмаар улсын төсөвт оруулах орлогын баазыг бэхжүүлэх бодлогын зорилтуудад чиглэсэн байна.

Тайлант хугацаанд олборлолт, уул уурхай хөтөлбөрт 47,780.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 33,598.3 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 78.1 хувьтай санхүүжсэн бол хөтөлбөр арга хэмжээ 93.4 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнасан нь хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн сахилга, төлөвлөлтийн түвшин нийтэд нь хангалттай байсныг илтгэж байна. Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийн дийлэнх нь батлагдсан хугацаанд хэрэгжсэн бөгөөд бодлогын зорилтыг хангахуйц бодит үр дүн гарсан байна.

Геологийн судалгаа, хайгуулын чиглэлээр улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь салбарын мэдээллийн суурийг өргөжүүлсэн бодит үр нөлөө үзүүлжээ. Тухайлбал, 707 геологийн судалгааны тайлан баталгаажсан нь зорилтот түвшин (900)-д бүрэн хүрээгүй боловч, хайгуулын төлөвлөгөө 1,173, уулын ажлын тайлан 307, уулын ажлын төлөвлөгөө 543 тус тус батлагдаж, эдгээр үзүүлэлт нь төлөвлөсөн түвшнээс давсан гүйцэтгэлтэй байна.

Үүний үр дүнд 16,983 км<sup>2</sup> талбайд геологийн судалгаа хийгдэж, 9 төрлийн ашигт малтмал, 3 төрлийн барилгын материалын нөөцийн мэдээлэл, 701 эрдэсжсэн цэг, 54 эрлийн талбай шинээр тогтоогдсон нь цаашдын ашиглалт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой мэдээлэл болж байна.

Уул уурхайн олборлолт, экспортын үзүүлэлтүүд бодлогын үр дүнг тоон мэдээллээр илтгэж байна. Тайлант хугацаанд нүүрсний экспорт 89.9 сая тонн болж, төлөвлөгөөт 83.3 сая тонноос давсан бол зэсийн баяжмалын экспорт 2.2 сая тонн хүрч зорилтот түвшнээс (1.78 сая тонн) давсан гүйцэтгэл үзүүлжээ.

Харин төмрийн хүдрийн экспорт 8.8 сая тонн болж зорилтот түвшинд дөхсөн бол алт 11.36 тонн, газрын тос 3.7 сая баррелийн гүйцэтгэл нь төлөвлөгөөнөөс доогуур гарсан нь олон улсын зах зээлийн нөхцөл байдал, олборлолт-технологийн хүчин чадал, дэд бүтцийн хязгаарлалтаас шалтгаалсан гэж үзэх үндэслэлтэй.

Салбарын эдийн засагт үзүүлсэн нөлөөллийн хувьд, ашигт малтмалын үйл ажиллагаанаас ойролцоогоор 44,800.0 сая төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр улсын төсөвт төвлөрүүлсэн нь төлөвлөсөн 30,000.0 сая төгрөгөөс 14,800.0 сая төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна. Мөн улсын хөрөнгөөр хайгуул хийсэн ордоос 3,200.0 сая төгрөгийн нөхөн төлбөр төвлөрүүлсэн нь төсвийн орлогын баазыг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулжээ.

Гэсэн хэдий ч тайлангаас үзэхэд зарим арга хэмжээний хэрэгжилт нь тоон зорилтоо хангаж байгаа боловч урт хугацааны эдийн засгийн өгөөж, нэмүү өртөг, боловсруулах үйлдвэрлэлд үзүүлэх нөлөөллийг тайлагналд хангалттай тусгаагүй сул тал ажиглагдаж байна.

Иймд цаашид салбарын хөтөлбөр, арга хэмжээг үр нөлөө, бодлогын тогтвортой байдлыг харуулах шалгуур үзүүлэлтээр баяжуулан үнэлэх, гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан дүгнэх шаардлагатай гэж үзэж байна.

### 3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Үндэсний геологийн алба, Ашигт малтмал, газрын тосны газрын нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 1,672.4 сая төгрөг төвлөрч, 1,587.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хувьд Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аж үйлдвэржилтийн төслүүдийг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын нөөц сангаас 2,645.9 сая төгрөгийг зарцуулах эрх олгогдсоноос 1,274.8 сая төгрөгийг зориулалтын дагуу ашигласан байна. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Интегра” төслийн хүрээнд 70.3 сая төгрөгийн санхүүжилт авч, холбогдох үйл ажиллагаанд зарцуулжээ.

Үндэсний геологийн албаны нэмэлт санхүүжилт нь олон улсын болон байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд бүрдсэн бөгөөд Бүгд Найрамдах Франц Улсын геологийн байгууллагатай хэрэгжүүлж буй “Литий-Монгол” төслийн 73.6 сая төгрөг, Архивын ерөнхий газраас олгосон гэрээт ажилтны цалингийн 24.1 сая төгрөг, БНСУ-ын “KIGAM” байгууллагатай байгуулсан гэрээний хүрээнд 141.0 сая төгрөг, түүнчлэн үйлчилгээний орлогоос 2.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын хувьд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй 2025 оны 7 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан 01003638 дугаар гэрээний хүрээнд 45.5 сая төгрөг, мөн Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын холбогдох тогтоолуудаар батлагдсан “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 5 албан хаагчийн урамшуулал болон нэмэгдэлд 32.3 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### Салбарын хэмжээнд хийсэн судалгааны нэгтгэл

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааны үр дүнг танилцуулж байна. Үүнд:

##### 1. Бүтэц, орон тоо, цалингийн зардлын хэрэгжилт

Салбарын хэмжээнд орон тоог 9–10 хувиар бууруулсан бөгөөд тухайлбал яам 99-өөс 90, Ашигт малтмал, газрын тосны газар 200-гаас 180, Үндэсний геологийн алба 35-аас 32, Цөмийн энергийн комисс 33-аас 30 орон тоонд шилжсэн байна. Гүйцэтгэлээр зарим байгууллага батлагдсан түвшнээс доогуур ажилласан (жишээлбэл, Эрчис ойл ХХК 123 батлагдсан орон тооноос 95, Геологийн судалгаа-шинжилгээний төв 223-аас 215). Үүний үр дүнд цалингийн зардалд хэмнэлт үүссэн (жишээлбэл, АМГТГ 242.0 сая төгрөг, ГСШТ 303.4 сая төгрөг).

##### 2. Хоол, унааны хөнгөлөлтийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл

Зардлын гүйцэтгэл байгууллагуудаар харилцан адилгүй байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд 572.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 638.6 сая төгрөг зарцуулж 65.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн бол Ашигт малтмал, газрын тосны газарт 899.7 сая төгрөгөөс 868.4 сая төгрөг зарцуулж 31.3 сая төгрөг, Цөмийн энергийн комиссын ажлын алба 188.0 сая төгрөгөөс 140.3 сая төгрөг зарцуулж 47.7 сая төгрөг, Эрчис ойл ХХК-д 436.6 сая төгрөгөөс 272.7 сая төгрөг зарцуулж 163.9 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Хоолны хөнгөлөлт

13.0-30.0 мянган төгрөгийн хооронд (АҮЭБЯ, АМГТГ, ҮГА 30.0 мянга, ЦЭКАА, Эрчис ойл ХХК 20.0 мянга, ГСШТ 13.0 мянга), унааны хөнгөлөлт 2.0-3.0 мянган төгрөгийн хооронд (АҮЭБЯ, АМГТГ, ҮГА, ЦЭКАА 3.0 мянга, ГСШТ, Эрчис ойл ХХК 2.0 мянган төгрөг) батлагдсан байна.

### 3. Гадаад, дотоод томилолтын зардлын хэрэгжилт

Гадаад томилолтын зардал байгууллагуудаар зөрүүтэй хэрэгжсэн байна. Ашигт малтмал, газрын тосны газарт 2024 онтой харьцуулахад 59.4 сая төгрөгөөр буюу 76.3 хувиар өссөн (137.3 сая төгрөг), яаманд төлөвлөгөөгүй 19 удаагийн томилолтод 96.8 сая төгрөг зарцуулсан бол Эрчис ойл ХХК 125.6 сая төгрөг батлагдсанаас 25.2 сая төгрөг буюу 20.1 хувийг зарцуулсан байна. Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ гадаад томилолтод 108.9 сая төгрөг, дотоод томилолтод 178.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 4. Сургалт, семинарын зардал, хэрэгжилт

Сургалтын үйл ажиллагаа өргөн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газарт 16 төрлийн сургалтад 461 албан хаагч хамрагдсан, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ 40 сургалтад 18.3 сая төгрөг, Эрчис ойл ХХК-д сургалт, хуралд нийт 56.4 сая төгрөг, яаманд нэмэлт сургалтад 6.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Гэвч зардлын үр ашиг, төлөвлөлтийн уялдаа хангалтгүй байна.

### 5. Биет бус хөрөнгийн бүртгэл, ашиглалт

Ашигт малтмал, газрын тосны газарт 1,422.4 сая төгрөгийн өртөг бүхий 37 төрлийн биет бус хөрөнгө бүртгэлтэй бөгөөд элэгдлээрээ өртгөө нөхсөн хэдий ч ашиглагдсаар байгаа, мөн 250.0 сая төгрөгийн “Mpetro smart solution” программ бүртгэлд тусгагдаагүй байна. Геологийн судалгаа-шинжилгээний төвд 97.3 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй, Үндэсний геологийн албанд ашиглагдаагүй 1 программ, 4 лиценз бүртгэлтэй байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь 137.4 сая төгрөгийн өртөг бүхий 3 төрлийн программ хангамж (Үйлдвэр технологийн паркийн нэгдсэн мэдээллийн сан, санхүүгийн аcolous программ, монгол бичгийн хөрвүүлгийн толь бичиг) ашиглаж байна.

### 6. Хэвлэл мэдээллийн зардал, хэрэгжилт

Тайлант онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах хүрээнд 6 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, нийт 118.2 сая төгрөгийн зардал гаргасан бөгөөд харьяа бусад байгууллагуудад хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал бүртгэгдээгүй байна. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын судалгаа, статистик мэдээ, мэдээлэл бэлтгэх, олон нийтийг нээлттэй, ил тод мэдээллээр хангаж сурталчлан таниулах зорилгоор newslife.mn, mining.mn, livetv.mn, 24tsag.mn, mass.mn, tsenzuur.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулахад 39.3 сая төгрөг,
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллаатай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэх, зөвшөөрсөн мэдээллийг tsenzuur.mn, 24tsag.mn, mining.mn, newslife.mn, zogii.mn, livetv.mn, tsahiur.mn, mass.mn, ubn.mn, zarig.mn, tsahimnews.mn сайтад байршуулахад 59.1 сая төгрөг, салбарын мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор tsahimnews.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулахад 19.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, чиг үүрэг болон төсөвлөлтийн уялдаа, оновчтой байдлыг хангах чиглэлээр өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 03/994 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувь буюу 62,517.0 сая төгрөгөөр тогтоосон. Аудитын явцад уг суурь үзүүлэлтийг дахин үнэлэхэд, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудалд шилжсэн нь тайлангийн хамрах хүрээ, хэмжээнд бодит өөрчлөлт үүсгэсэн тул материаллаг байдлын түвшинг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Иймд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувь буюу 4,589.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах, цахим худалдан авалт арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй бөгөөд төсөвт ном хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал батлагдаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

## Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн зөрчил

Харьяа байгууллагуудад нийцлийн асуудлаар нийт 74,162.0 сая төгрөгийн 23 зөрчил илэрч, 72,098.2 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 2,063.8 сая төгрөгийн зөрчилд 17 зөвлөмж өгсөн.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд нийт 1,362 мэдээлэл байршуулбал зохих ёстойгоос 1,327 мэдээллийг бодитой байршуулж, үүнээс 1,260 мэдээллийг хуульд заасан хугацаанд, 67 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг 94.7 хувиар үнэлсэн байна. Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим системд нийт 32 удаа тайлан илгээж ажилласан байна.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй зөрчил дараах байдлаар илэрлээ. Үүнд:

- **Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам** нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах 178 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй, мөн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлсэн;
- **Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ**-ын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан орлого, зарлагын мэдээллийг мөнгөн хөрөнгийн дансны дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад орлогын 377.0 сая төгрөгийн 7, зарлагын 1,686.9 сая төгрөгийн 18 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрч, зөвлөмж өгсөн;
- **Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ** нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах 182 мэдээллээс 178 мэдээллийг байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлсэн.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын хүрээнд нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлүүдэд 1 албан шаардлага хүргүүлж, 10 зөрчилд нийт 8 зөвлөмж өгсөн. Үүнд:

#### Албан шаардлага

**Илрүүлэлт:** Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оноос өнөөг хүртэл хийгээгүй, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх нөөц боломжийг алдагдуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-т “Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар олгосон бүрэн эрхтэй. Түүний дотор:”, 1-д “эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ”,

Засгийн газрын 2013 оны 291 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам”-ын 3.1-т “Сонгон шалгаруулалтыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон өдөр тутмын хэвлэл, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар сонгон шалгаруулалт болохоос 30 хоногийн өмнө зарлана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээ, төслүүдийн хэрэгжилт нь санхүүжилт, зохион байгуулалт, хяналтын тогтолцооны сул байдлаас шалтгаалан төлөвлөсөн хугацаанд хангалттай хэрэгжээгүй, стратегийн зорилт, үр дүнгийн үзүүлэлтүүд биелээгүй байна. Тухайлбал:

***Илрүүлэлт 1.*** Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тодорхойлсон 2 зорилго, 3 зорилтын 4 арга хэмжээний 18 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг 88.9 хувьтай үнэлэгдсэн гэж тайлагнасан байна. Гэвч стратегийн ач холбогдол бүхий дараах төслүүд хугацаандаа бүрэн хэрэгжээгүй, бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хууль, Засгийн газрын шийдвэрийн шаардлагад нийцээгүй байна. Тухайлбал:

- Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах ажил бүрэн хэрэгжээгүй;
- Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангагдаагүй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай–металлурги химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах ажил дуусаагүй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ил уурхайн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл хийгдээгүй;
- Дорноговь аймагт “Алтанширээт” аж үйлдвэрийн парк байгуулах ажил хэрэгжээгүй;
- Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь” кокс, металлургийн үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажил бүрэн дуусаагүй;
- Газрын тос боловсруулах үйлдвэр барих ажил бүрэн хэрэгжээгүй байна.

***Илрүүлэлт 2.*** Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ, төслүүдийн хэрэгжилт санхүүжилт, зохион байгуулалтын хангалтгүй байдлаас шалтгаалан төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжээгүй, 59.6 хувьтай үнэлэгдсэн байна.

Энэ нь бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн шаардлагыг бүрэн хангаагүй, салбарын бодлогын хэрэгжилтийн сахилга, хариуцлагын тогтолцоо сул, стратегийн зорилт, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, тайлагналын уялдаа алдагдсан байна. Тухайлбал:

- “Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлэх” зорилт хэрэгжээгүй;

- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн далд уурхайн ашиглалт, экспортын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжээгүй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд уул уурхай–металлурги, химийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах ажил дуусаагүй;
- Оюутолгой ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулж, катодын зэс, алт, мөнгө зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хэрэгжээгүй;
- Далд уурхайн төсөл, катодын зэс үйлдвэрлэх төсөл, “Монгол ган цогцолбор-1”, Алтанширээт аж үйлдвэрийн парк, Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр зэрэг стратегийн ач холбогдол бүхий төслүүд хэрэгжээгүй;
- Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлж, дотоодын ган бүтээгдэхүүний хэрэгцээг хангах зорилт биелэгдээгүй байна.

**Илрүүлэлт 3.** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр туссан зарим гол зорилт, арга хэмжээ төлөвлөлт оновчтой бус, төсөв санхүүгийн эх үүсвэр дутмаг, хэрэгжилтийн хяналт сул байсантай холбоотойгоор хангалтгүй хэрэгжсэн байна. Тухайлбал:

- Үйлдвэрийн парк, технологийн дэвшил нэвтрүүлэх төслүүдийн хэрэгжилт удаашралтай, төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэл хангагдаагүй;
- Эрдэс баялгийн боловсруулах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт, өргөтгөлийн ажлууд бүрэн хэрэгжээгүй, үйлдвэрлэлийн хүчин чадал бодлогын зорилтод хүрээгүй;
- Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд дэд бүтцийн төслүүдийн санхүүжилт, зохион байгуулалт хангалтгүй, улмаар салбарын хөгжлийн үр өгөөжийг хязгаарласан;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сул, бодлогын хэрэгжилтийн явцад ил тод байдал, үр дүнгийн хэмжүүр хангалтгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

1. Салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээ, стратегийн ач холбогдол бүхий төслүүдийн хэрэгжилтийг хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэртэй уялдуулан бодит нөхцөл, санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх чадавхад нийцүүлэн дахин төлөвлөж, хэрэгжилтийн тодорхой үе шат, шалгуур үзүүлэлт, хариуцагч, хугацааг нарийвчлан тогтоох;
2. Төслүүдийн хэрэгжилт удааширч, бүрэн хэрэгжээгүй шалтгаан болох санхүүжилт, дэд бүтэц, зөвшөөрөл, зохион байгуулалтын хүндрэл, уялдаа холбооны асуудлыг төсөл тус бүрээр үнэлж, шийдвэрлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжилтийг эрчимжүүлэх;
3. Салбарын түвшинд бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, тайлагналын уялдаа холбоог сайжруулж, гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоо, хариуцлагын механизмыг боловсронгуй болгон, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол үнэлж, ил тод тайлагнах;

4. Бодлогын хэрэгжилтийг зөвхөн тоон гүйцэтгэлээр бус үр дүн, эдийн засгийн өгөөж, салбарын үйлдвэрлэл, экспорт, нэмүү өртөгт үзүүлж буй бодит нөлөөллөөр үнэлдэг аргачлал нэвтрүүлж, стратегийн зорилт, зорилтуудын биелэлтийг хангах.

**Илрүүлэлт 4.** Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай зарим зохицуулалт, норматив баримт бичиг батлагдаагүй байгаа нь бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээний тогтолцоонд сул тал үүсгэж байна. Үүнд:

- Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батлаагүй;
- Ашигт малтмал болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлал батлуулаагүй;
- Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журмыг батлуулаагүй.

Энэ нь Цөмийн энергийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10-т "Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батална",

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дангаар, эсхүл доор дурдсан төрийн байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад нийцсэн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг батална: 7.2.12. ашигт малтмал болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран",

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журмыг Засгийн газар тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Салбарын үйл ажиллагаанд шаардлагатай зохицуулалт, норматив баримт бичгүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн нэгдсэн арга зүйгээр боловсруулж, батлуулах ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, тайлагнал, хариуцлагын тогтолцоог тодорхой болгон мөрдүүлэх.

**Илрүүлэлт 5.** Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт, хяналт сул байгаагаас улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж бүрэн ашиглагдахгүй байна. Тухайлбал:

- Оюу толгой төсөлтэй холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилт сул байгаагаас УИХ-ын 2019 оны "Оюу толгой ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай" 92-р тогтоол, 2021 оны "Оюу толгой ордоос Монгол улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" 103-р тогтоол, УИХ-ын 2022 оны 02, 03-р түр хорооны тогтоолуудын хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байна.
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ (Петрочайна Дачин Тамсаг, Доншен газрын тос) шинэчлэл удааширч, татварын маргаан шийдэгдээгүй, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03-р тогтоол хэрэгжээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд УИХ-ын холбогдох тогтоолуудын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалтаар эрчимжүүлж, Оюу толгой болон газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүрэг, арга хэмжээний биелэлт, саатлын шалтгааныг иж бүрэн үнэлэн шийдвэрлэх, гэрээний шинэчлэл болон татварын маргааныг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай эцэслэх, цаашид хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, тайлагнал, хариуцлагын тогтолцоог тодорхой болгон мөрдүүлэх.

**Илрүүлэлт 6.** Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 4 төсөвт байгууллагын 3-ынх нь төсөв захирагч (АҮЭБЯ, АМГТГ, ҮГА) түр томилгоотой байгаа нь "төрийн жинхэнэ албан хаагчийг томилох" зарчим, "албан тушаалын томилгоог тогтвортой байлгах" шаардлагад нийцэхгүй байна. Түр томилгоо удаан хугацаагаар үргэлжилж байгаа нь удирдлагын тогтвортой байдал, хариуцлагын тогтолцоог сулруулж, байгууллагын менежмент, төсвийн сахилга бат, бодлогын хэрэгжилтэд тодорхойгүй байдал үүсгэж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, 42 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл", 43 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-тай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсөвт байгууллагуудын төсөв захирагчийн албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, байнгын томилгоог шуурхай хийх, түр томилгооны хугацааг хязгаарлан зохистой хэрэглэх.

**Илрүүлэлт 7.** Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.6, 11.1.7-д тус тус заасан геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөвлөгөө, тайлан болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээнд хяналт тавих, ашигт малтмалын тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч бүртгэн шийдвэрлэх чиг үүргийг Ашигт малтмал, газрын тосны газрын геологийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлж байна.

Гэвч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Үндэсний геологийн алба нь геологийн чиг үүргийг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд ижил төстэй чиг үүргийг Ашигт малтмал, газрын тосны газрын бүтцэд давхар хариуцуулсан нь байгууллагуудын чиг үүргийн давхардлыг бий болгож, эрх хэмжээний хуваарилалт, хариуцлагын тогтолцооны зааг тодорхой бус болох, улмаар удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээний үр нөлөө сулрах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Геологийн чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд заасан чиг үүргийн хуваарилалт, хэрэгжилтийн зохицуулалтыг иж бүрэн үнэлж, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны чиг үүрэг, эрх хэмжээ, хариуцлагын заагийг хууль, дэд норматив актын түвшинд тодорхой болгон ялган зааглаж, давхардсан чиг үүргийг оновчтой цэгцлэн шилжүүлэх, улмаар салбарын удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээний уялдаа, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэн мөрдүүлэх.

**Илрүүлэлт 8.** Үндэсний геологийн албаны жил бүрийн төсөв, судалгааны ажлын төлөвлөгөө нь стратегийн түвшинд батлагдсан бодлого, хөтөлбөртэй уялдаагүй, зөвхөн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийн хүрээнд төлөвлөгдөж байна.

Энэ нь Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-т "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ",

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндэсний геологийн албаны жилийн төсөв, судалгааны ажлын төлөвлөлтийг салбарын стратегийн бодлого, хөтөлбөр, дунд болон урт хугацааны зорилттой уялдуулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих зохицуулалтыг тодорхой болгож, төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн уялдаа холбоог хангах тогтолцоог бүрдүүлэх.

**Илрүүлэлт 9.** Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор Аж үйлдвэржилтийн үндэсний хороог байгуулж, 2025 онд хэрэгжүүлэх аж үйлдвэржилтийн төслүүдийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэсэн бөгөөд Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор нийт 2,645.9 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас олгохоор шийдвэрлэсэн байна.

Гэвч уг шийдвэр нь “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасан төсөвт тусгагдаагүй, гэнэтийн болон зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлын үед ашиглах шаардлагад нийцээгүй байна.

Энэ нь “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.2.2-т “урьдчилан тооцож төлөвлөх, эсхүл батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг тусгаагүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Урьдчилан төлөвлөх боломжтой аж үйлдвэржилтийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дунд хугацааны төсвийн төлөвлөлтөд тусган батлуулах, холбогдох байгууллагуудтай уялдуулан төсөвт суулгах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

**Илрүүлэлт 10.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 131,430.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 33.6 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 64,374.0 сая төгрөгийн зөрчилд 38 албан шаардлага хүргүүлэн, 67,014.6 сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж өгч, 8.7 сая төгрөгийн зөрчилд 3 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Мөн аудитаар нийт 74,162.0 сая төгрөгийн нийцлийн зөрчил илэрснээс 72,098.2 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 2,063.8 сая төгрөгийн зөрчилд 26 зөвлөмж өгсөн нь байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй байгааг илтгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн тайлагналын үнэн зөв, иж бүрэн байдлыг хангах зорилгоор дотоод хяналтын тогтолцоог эрсдэлд суурилсан зарчмаар бэхжүүлж, бүртгэл, тайлагналын үйл явцад хэрэгжих хяналтын орчин, үйл ажиллагаа, мэдээлэл, харилцаа, мониторингийн бүрэлдэхүүн хэсгүүдийг оновчтой зохион байгуулах, илэрсэн зөрчилд өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, биелэлтийн үр дүнд суурилсан хяналт, тайлагналын механизмыг төлөвшүүлэх, нийцлийн зөрчлийг бууруулах чиглэлээр хууль, журам, стандартын хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг уялдуулан хэрэгжүүлж, холбогдох албан тушаалтны хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн аудитын горим, сорилын үр дүнд үндэслэн, шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох шаардлагад бүрэн нийцээгүй, мөн бусад холбогдох хууль, журмын хүрээнд шалгасан үзүүлэлтүүд тогтоосон шалгуурыг хангаагүй гэж дүгнэв.

#### **4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 3 албан шаардлага, 6 зөвлөмж, 2 хариуцлага тооцох албан шаардлагын хэрэгжилт 81.8 хувьтай байна.

Хэрэгжилт хангагдаагүй сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцагчдыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2020 оноос хойш зохион байгуулаагүй, мөн газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүйтэй холбоотой зөрчлүүдэд өгсөн хоёр зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар албан шаардлага хүргүүлэх шийдвэр гаргалаа.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	3	477.3	3	477.3	100.0
2	Зөвлөмж	6	0.0	4	0.0	66.7
3	Хариуцлага тооцох	2	0.0	2	0.0	100.0
<b>Нийт дүн</b>		<b>11</b>	<b>477.3</b>	<b>9</b>	<b>477.3</b>	<b>81.8</b>

Өмнөх жилийн аудитаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 7 байгууллагад 67 аудитын арга хэмжээ хүргүүлсэн бөгөөд үүнд 11 төлбөрийн акт, 27 албан шаардлага, 27 зөвлөмж, 2 хариуцлага тооцох албан шаардлага тус тус багтсан байна. Аудитын арга хэмжээний бүтцэд албан шаардлага, зөвлөмж давамгайлж, мөнгөн дүн бүхий төлбөрийн акт харьцангуй бага хувийг эзэлж байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

*1. Концессын гэрээгээр Рашаант дахь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах барих төслийн ажлын талаар*

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 71-д Рашаант дахь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах барих төслийг өмчлөх, ашиглах төрлөөр хэрэгжүүлэхээр баталж, Засгийн газрын 2015 оны 119 дүгээр тогтоолоор Нэйшнл Трейдинг Энд Транспорт Групп ХХК-тай концессын гэрээг Үндэсний хөгжлийн газар /хуучнаар Хөрөнгө оруулалтын газар/ байгуулсан. Гэвч энэ хугацаанд 3,583.9 сая төгрөгийн хэрэгжилт гарч, дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй байгаа бөгөөд Үндэсний хөгжлийн газраас гэрээг сунгасаар байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/90 дүгээр тушаалаар дээрх гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан байна.

*2. Төрийн сангийн холбогдох журмын шаардлагыг зөрчиж, 2025 оны 12 дугаар сарын 25-наас хойш нийт 14,113.4 сая төгрөгийн дүн бүхий 103 удаагийн урсгал зардлын гүйлгээ хийгдсэн бөгөөд Төрийн сангийн анхан шатны хяналт сул хэрэгжсэн байна.*

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 26,993.4 сая төгрөгийн 16 алдаа илэрснээс 26,812.5 сая төгрөгийн 15 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5.5 сая төгрөгийн 1 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 131,430.9 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 33.6 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт, 64,374.0 сая төгрөгийн зөрчилд 38 албан шаардлага, 8.7 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага, 67,014.6 сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж тус тус өгсөн.

Аудитаар илэрсэн санхүүгийн тайлагналтай холбоотой 131,430.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 4,589.8 сая төгрөгөөс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 8 санхүүгийн тайланг нэгтгэж, үүнээс 7 байгууллагад аудитын дүгнэлт гаргасан бөгөөд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрөнгө оруулалтын дансны санхүүгийн тайланд аудитын үе шатны горимыг хэсэгчлэн хэрэгжүүлсэн.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 1 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 6 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### 5.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит

#### Аудитаар илэрсэн зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүнд 1,450.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, чиг үүрэгт нь хамааралгүй Үндэсний геологийн албаны санхүүгийн тайланд ураны ордын технологийн туршилттай холбогдуулан байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх баталгааг байршуулсан зөрчилд 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

#### 5.1.1. Албан шаардлага

**Илрүүлэлт:** Газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон холбогдох баримт бичгийг 2013 онд 1,450.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй бөгөөд уг зардлыг Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн “Дуусаагүй барилга байгууламж” дансанд бүртгэн тусгасан байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 2.2.10.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон холбогдох баримт бичгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1.2. Зөвлөмж

**Илрүүлэлт:** Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоолоор Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Зөөвч-Овоо ордын MV-018915 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Бадрах Энержи ХХК-д ураны ордын технологийн туршилттай холбогдуулан байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх баталгаа болгон 900.0 мянган ам.доллартой тэнцэх мөнгөн хөрөнгийг Төрийн сангийн холбогдох дансанд байршуулах үүргийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд даалгасан байна.

Гэвч уг хөрөнгийг чиг үүрэгт нь хамааралгүй Үндэсний геологийн албанд хариуцуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шийдвэрээр 2020 онд тус байгууллагыг бие даасан агентлаг болгон өөрчлөн зохион байгуулах үед санхүүгийн тайлангийн өр төлбөрийн дансанд 2,433.2 сая төгрөгөөр бүртгүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоолоор үүрэг болгосон баталгааны хөрөнгийн удирдлагыг зориулалтын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад төвлөрүүлж, Төрийн сангийн зохих дансанд бүртгэн хяналтыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

№	Байгууллага нэгжийн нэр	Аудитын код	2025 оны санхүүгийн тайлангийн аудит		Дүгнэлт						Аудит хийсэн байгууллагын нэр	
			ҮАГ	АНТАГ	АХЭ	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт гаргахаас татгалзсан	Түүвэрт		Аудитад хамрагдаагүй
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ТЕЗ	САГ-2026/1/НА-СТА-ТЕЗ	1				1					Үндэсний аудитын газар
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	САГ-2026/3/НА-СТА-ТШЗ	1				1					Үндэсний аудитын газар
3	Ашигт малтмал, газрын тосны газар	САГ-2026/19/НА-СТА-ТШЗ	1				1					Үндэсний аудитын газар
4	Үндэсний геологийн алба	САГ-2026/247/НА-СТА-ТШЗ	1				1					Үндэсний аудитын газар
5	Цөмийн энергийн комиссын ажлын алба	САГ-2026/308/НА-СТА-ТШЗ			1		1					Ирмүүн Хантайшир Аудит ХХК
6	Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ	САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ			1		1					Анализ старт аудит ХХК
7	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ	САГ-2026/88/НА-СТА-ТӨҮГ			1	1						Аккурэйт финанс Аудит ХХК
8	Эрчис ойл ХХК	САГ-2026/93/НА-СТА-ТӨҮГ			1		1					Дундманхайдай Аудит ХХК
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрөнгө оруулалт	САГ-2026/4/НА-СТА-ТШЗ	1							1		Үндэсний аудитын газар
	<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	1	189.5		-	1	189.5	1	189.5		-		-
2	Ашигт малтмал, газрын тосны газар	3	2,117.8		-	3	2,117.8	2	2,112.2	1	5.5	1	5.5
3	Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ	6	24,402.1	1	180.8	5	24,221.3	6	24,402.1		-		-
4	Үндэсний геологийн алба	4	80.8		-	4	80.8	4	80.8		-		-
5	Цөмийн энергийн комиссын ажлын алба	1	176.9		-	1	176.9	1	176.9		-		-
6	Эрчис ойл ХХК	1	26.3		-	1	26.3	1	26.3		-		-
	<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>26,993.4</b>	<b>1</b>	<b>180.8</b>	<b>15</b>	<b>26,812.5</b>	<b>15</b>	<b>26,987.8</b>	<b>1</b>	<b>5.5</b>	<b>1</b>	<b>5.5</b>

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Дүн
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ТЕЗ	2	1,450.0			1	1,450.0	1	-			
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	13	3,567.5	1	1.1	9	566.8	1	2,999.6	1		-
3	Ашигт малтмал, газрын тосны газар	13	65,798.4		-	8	19,793.3	5	46,005.1			-
4	Геологийн судалгаа-шинжилгээний төв	16	1,881.7	3	10.4	5	745.7	7	1,125.6	1		-
5	Үндэсний геологийн алба	11	43,202.5	2	8.3	7	41,710.6	2	1,483.6			-
6	Цөмийн энергийн комиссын ажлын алба	3	91.9	1	8.4		-	1	74.7	1		8.7
7	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж	2	3.6	1	3.6		-	1	-			-
8	Эрчис ойл ХХК	16	15,435.3	2	1.8	8	107.6	6	15,326.0			-
	<b>Бүгд</b>	<b>76</b>	<b>131,430.9</b>	<b>10</b>	<b>33.6</b>	<b>38</b>	<b>64,374.0</b>	<b>24</b>	<b>67,014.6</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>8.7</b>

#### 6.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ТЕЗ	8	-					8	-
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	5	-		-	2	-	4	-
3	Ашигт малтмал, газрын тосны газар	6	-		-		-	6	-
4	Геологийн судалгаа-шинжилгээний төв	4	2,142.6		-	2	78.7	2	2,063.8
5	Үндэсний геологийн алба	4	-		-		-	4	-
6	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж	3	279.9			2	279.9	1	-
7	Эрчис ойл ХХК	1	71,739.6		-	1	71,739.6		-
	<b>Бүгд</b>	<b>31</b>	<b>74,162.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>72,098.2</b>	<b>25</b>	<b>2,063.8</b>

/сая төгрөгөөр/



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1287/АД-111371

Улаанбаатар хот

САГ - 2026/1/НА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон холбогдох баримт бичгийг 2013 онд 1,450,000,000.0 (Нэг тэрбум дөрвөн зуун тавин сая) төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй бөгөөд уг зардлыг Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн "Дуусаагүй барилга байгууламж" дансанд бүртгэсэн байна.


Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:", 2.2.10-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон холбогдох баримт бичгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /Г.Дамдинням/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1288/AD111371

Улаанбаатар хот

САГ - 2026/1/НА - СТА - ТЕЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оноос өнөөг хүртэл хийгээгүй, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх нөөц боломжийг алдагдуулсан байна.


Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-д “Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар олгосон бүрэн эрхтэй. Түүний дотор:”, 1-д “эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ” Засгийн газрын 2013 оны 291 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам”-ын 3.1-д “Сонгон шалгаруулалтыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон өдөр тутмын хэвлэл, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар сонгон шалгаруулалт болохоос 30 хоногийн өмнө зарлана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оноос өнөөг хүртэл хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /Г.Дамдинням/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264350

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-1.Docx

1526182030